

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(13-36)

“BATU-METÜ” ЗЭРЭГ ҮГЭЭС -BTUR, -M/ATAGAI, -BČI,
-NTAY, -NČIR, -N/ČAY“ ЗЭРЭГ ДАГАВАР ҮҮССЭН НЬ

М. Базаррагчаа *

1. Өнгө зүсийг нэрлэсэн утгатай, ulayā-(n), čaya-n, noyuyā-n, boru-, köke-, sira-, čengker-, уayā-n, qara-, barayā-n, küre-n, qula-, kegēr-, čegē-n;

2. шинж чанарыг нэрлэсэн утгатай sāyi-n, mayū-, nomuqa-n, nomūi, dulaγā-n, uya-n, qayūrai-, qaranguūi, gegē-n, qayūci-n, adali-, čarayū, qatayū, jögēle-n, sayṣayū, nōyita-n, kimda, qaša-ng, sula, sinuqāi, mayū-qāi, qomuqāi-, turāngqāi-, ilamayāi, ayaytai-, baruytāi, irayū, yadayū-, qala-γū-n, kūyite-n, nilayū-n, γasiγū-n, asiγū-n, niγta-, ayliγū-, mulγū-, qoyūsun, sine;

3. хэлбэр дүрсийг нэрлэсэн утгатай qurča-, moquγā-, egče-, šuluyū-n, γonjuγui-, onduū-, jartayai-, dorsuyūi-, māyijijūi, qalčayai-, keltegeyi-, tegsi-, čombu-ng, qalja-n, urangqāi-, qajayai-, qabtayāi, jadayai, šūmayāi, narīn, бүдүгү-n, künγκür;

4. тоо хэмжээг нэрлэсэн утгатай tomu, baγa, namqan-, juγayan-, ūyita-n. qobur(a), ola-n, boγuni, urtu, dumda, qomsa, dutayū, tarγu, čögēn, күндү-, kōngge-n, öрге-n

5. цаг хугацааг нэрлэсэн утгатай udayā-n, түмге-n, ayāji-m, ānāyi, nayājayāi-, nasutāi-, (erte-), (sayi-), (darūi), (orūi), aljaū-, уayāraū, jalayū-, ayāji-γū-, dabči-γū-, qurdu-n, siγūrqāi-, šalam-γāi

6. орон зайг нэрлэсэн утгатай qola-, oyira-, bačiγū-, (dabči-γū-), (bariγū-), ibčau, uru-γū¹ зэрэг тэмдэг нэрнээ орох харьцуулан бууруулсан утга бүхий "-btur ~ -tur" дагавар нь утгаа адилтгах утга бүхий "metū-" (адил шиг), metū-čile- (адилтгах зэрэг сэлт), metürkeū (адилавар, төстэй), metüs (мэтийн олон тооны дагавар авчээ) хэмээх үгийн "m" нь "b"-тэй сэлгэж, арын эгшиг нь гээгдсэнээс үүссэн ба зарим үгнээ "b" нь ч гээгдэх бий. Жишээ нь, sāyi- (b)-tur → sāyi-tur, sāyi-qan-tur, baγan-(b)-tur → bayatur, āyi-qu(b)-tur → āyi-qu-tur, iči-gū(b)-tür → ičigütür.

Н.Поппе "-btur" дагаврыг шинж чанар заасан утгат дагаврын бүлэгт багтаан, багасгах утгад хамтатган буурангуй өнгийг илтгэдэг дагавар² гээд qara-btur, ulaqa-btur,

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹⁾ М.Базаррагчаа, *Монгол хэлний өгүүлбэр судлал*, Улаанбаатар, 2005, 165-173-р тал.

²⁾ Н.Н. Поппе, *Грамматика письменно-монгольского языка*. М.- Лгр, 1937, стр. 107-108.

sira-btur гэсэн жишээ татаж, энэхүү "буурангуй" утга бүхий, , -bir (ša..ā-bir), -bur (ulaqā-bur, sira-bur), -btür (köke-btür) хэмээх гурван дагаврыг дурджээ.

Буриад хэлний дагаврыг дагнан судалсан У.Ж.Ш. Дондуков энэ дагаврын тухай а) буурангуй зөөлөн өнгө (ногоо-бтор, улаа-бтар); б) тийн мэдрэхүйн үүднээс юмсын шинж чанарыг зөөлрүүлэх (гашуу-бтар, шэнгэ-втэр, халуу-бтар, хууша-бтар); в) хүн, амьтны бие махбодийн гадаад шинж байдал (халза-бтар, залуу-бтар, хашан→ хашаб-тар (слечка с ленцой); г) орон цагийн шинж харьцаа (уйта-бтар, сэхэ-бтэр (довольно прямоватый), холо-бтор); д) аль нэг юмсын зарим шинжтэй адилавартай байх түхэрээ-бтэр (несколько кругловатый); торго-бтор, моһо-бтор, халюу-бтар (халиу) утгыг илтгэхээс гадна, уг үгийн салаа утгаас хүний сэтгэхүйн нөөц болон зан чанарыг илтгэсэн ухаа-бтар, шэрүү-бтэр, боро-бтор (энгийн)³ зэрэг үгс буйг тодорхойлжээ. Мөн энэ дагаврыг хааяа үйл үндэснээ garabtar, жэрхэ-бтэр (жийрхэх, зэвүүрхэх), гэсэн жишээг дурджээ. Харин Ш. Лувсанвандан энэ дагавар нь завсрын өнгө заасан тэмдэг нэр үүсгэх ба эцсийн "-н" ба заримдаа бүхэл үеийг гээж, ulaqā-n → ulagā-btur → ula-bur → ula-bir, sira-b(t)ur → sira-bur → čagan → čaga-btur → čaga-bur, köke-btür → kökebür зэрэг үг бүтдэгийг тэмдэглэжээ.⁴

П.Бямбасан багш тэмдэг нэрсийн утгыг эрчимжүүлэх ба бууруулах айн дотор -btur дагавар нь гол төлөв өнгө, хэлбэр, дүрс заасан үүсмэл бус тэмдэг нэрнээ залгаж, утгыг бууруулна (харавтар, шаравтар, хөхөвтөр, нарийвтар, гонзгойвтар, дугуйвтар, бүдүүвтэр), хааяа үүсмэл тэмдгийн нэрнээ үг дагаврыг залгаж, ядуувтар, гуншаавтар, онгироовтар, хазгайвтар, хэвтгийвтэр, туранхайвтар зэрэг үг бүтээн⁵ гэжээ. Мөн Ц. Жанчивдорж багш "Монгол хэлний тэмдгийн нэрний харьцангуй зэрэг бол бодис юманд байдаг бэлгэ чанарын ялгаврыг үзүүлэгч илтгэгч нь юм: Тэр нь монгол хэлэнд үг зүйн аргаар, тухайлбал, "-втар, -хан" дагавруудаар илэрнэ"⁶ гээд, "шив шинэ, яв ягаан, бөв бөөрөнхий, маш сайхан, хамгийн хүчит, туйлын бардам гэх мэтээр тэмдэг нэрийн харьцангуй зэргийг үгүүлбэр зүйн аргаар илрүүлж болно" гэсэн байна.

М.Н.Орловская "Орчин цагийн монгол хэлнээ бусад юмын шинж чанартай харьцуулалгүйгээр уг юмын шинж чанартай байх хир хэмжээг заадаг, тэмдэг нэрнээ залгах "-btur, -хан" гэсэн дагавар байдаг"⁷ гэсний -хан нь бидний үзэхээр бол сул баймжийн бүтээвэр болох ба М. Н. Орловская "-втар дагавар нь уул юмсын шинж, чанарыг бууруулах утгыг тэмдэглэдэг идэвхтэй хэрэглэгддэг дагавар юм" гэжээ. Тэрээр маш бүдүүн, нэн догшин, дэн бүдүүн, цэл хөх, час улаан, хав хар, шив шинэ гэх мэтээр уг юмны шинж чанарын хэр хэмжээг эрчимжүүлдэг тухай өгүүлжээ. С.Л. Чареков "-btur дагавар нь юмсын бууруу, бүрэн бус, бага хир хэмжээг заах утгатай бөгөөд өгүүлэгчийн

³ У.Ж.Ш. Дондуков, *Аффиксальное словообразование частей речи в бурятском языке*. Улан-Удэ, 1964, стр 71-72

⁴ Ш. Лувсанвандан, *Орчин цагийн монгол хэл*, Бээжин, 1961, 1962, 240-241-р тал.

⁵ П. Бямбасан, "Тэмдгийн нэр Орчин цагийн монгол хэл зүй", Улаанбаатар, 1966, 110-11-р тал.

⁶ Ц. Жанчивдорж, *Орчин цагийн монгол хэлний тэмдгийн нэрийн тухай*, Заах арга-эрдэм шинжилгээний хуудас, "Монгол хэл, утга зохиолын бүлэг" I, Улаанбаатар, 1961, 58-59-р тал.

⁷ М.Н.Орловская, *Имена существительные и прилагательные в современном монгольском языке*. Москва, 1961, стр. 95-96.

үнэлэмж, адил төстэй шинжийг илтгэнэ"⁸ гэж үзсэн нь А.А.Дарбеевагаас "тэмдэг нэрийн бууруулах (-бтар, бар, шаг: һулабтар, сагаабтар, сагаалтар, ногоолтор, шарабар, улабар, һагюушаг (сариушиг), набтаршаг) ба эрчимжүүлэх (саб сагаан, сэб сэгээн, тон залуухан, угаа сэсэн, шал һогтуу, сэл ногоон) утга илтгэдэг"⁹ гэснээс эхтэй аж. Өвөр монголын эрдэмтэн Цэнгэлтэй тэмдэг нэрийн харьцуулах айг

1. Ерийн буюу энгийн зэрэг: улаан, сайн, өндөр;
2. Татуу зэрэг: улаа-втар, хара-втар, цагаа-хан, их(ээ)-хэн;
3. Давуу зэрэг: у-в улаан, ха-в халуун, маш сайн, тун зүйтэй;
4. Харьцуулсан зэрэг: -аас+үндэс: уулаас өндөр, далайгаас гүн;
5. Үнэлсэн зэрэг: хамгийн, туйлын, эрхмээс эрхэм, туйлын сайн¹⁰ гэж ангилсан байна.

Мөн Ш.Цэцэнцогт "-btur" дагаврыг тэмдэг нэрийн харьцуулах айн "-btur, -tur" гэсэн хувилбар бүхий тухайн шинж тэмдгийг татуу болохыг илтгэх утгатай¹¹ гэж үзжээ. Үүнд: "аују-btur, аууqu-btur, күre-btur, sayi-btur, erte-bter" гэх мэт жишээ татжээ. Мөн Ц.Норжин гуай "-btur, -btar" дагавар нь уул хэмжээнээс арай дутуу шинжийг илтгэх утгатай¹², тэгш дүүрэн -btur, -btur, bur нь өнгийг бууруулан заасан үг бүтээх тухай,¹³ Г.Хайрхан тухайн утгын дагуу үүссэн юм үзэгдлийн шинж чанар, хир хэмжээний харьцангуй байдлыг заасан үг (köke-bter, ula-btur, çага-bur, ula-bir)¹⁴ бүтэх тухай дурджээ.

С.Галсан монгол хэлний тэмдэг нэрийг а) өнгө, б) шинж чанар в) орон цагийн, хэмжээ чанар (урт, өндөр, намхан) г) хүн амьтны шинж д) зан чанар, оюун ухаан (зальтай ухаантай) гэж утгаар нь ангилаад, "-btur" дагаврыг үнэлэмж заасан утгатай бол "цав цагаан" гэвэл тэмдэг нэрийн дээд зэргийг илтгэсэн утгатай¹⁵ гэжээ.

Д.Д. Амоголонов -бтар (чанар дутмаг) "-маг" (чанарын их буюу бага зэрэг гэдэг) "-хан" (чанарын дутмаг, бууруу) гэсэн харьцуулсан зэрэг илтгэх дагавар байхын дээр тэмдэг нэрийн давуу зэргийг илтгэх а) эрчимжүүлэх бүтээвэр (тон, маша, угаа)

б) сайнаас сайн, муугийн муу гэж давтаж, в)гасархай үндэс (уб улаан, оро обогор, тэрэ тэбхэр); г) туслах үйл үг гэ- (ехэ гэгшын хада, томо гэгшын том юумэн); д) богино эгшгийг урт болгодог дотоод нугарал (үндэр→үндээр→үндүүр, ехе→ехы)-ын аргаар илэрнэ.¹⁶ гэсэн бол Г.Д. Санжеев юмсын чанарыг эрчимжүүлэх ба бууруулахдаа 1)маша, угаа, эгээ, тун” зэрэг үгсийг угтуулах; 2) хайнһаа хайн гэж давтах 3) эхний

⁸⁾ С.Л. Чареков, *Прилагательные в монгольских языках в сравнении с другими алтайскими*, Лгр., 1990 стр. 28-29

⁹⁾ А.А. Дарбеева, *Имя прилагательные Грамматика бурятского языка. Фонетика и морфология*”, Москва, 1962, стр. 105-108.

¹⁰⁾ Цэнгэлтэй, *Одоо үеийн монгол хэлний зүй*. Хөх хот, 1980, 232-р тал.

¹¹⁾ Ш. Цэцэнцогт, *Монгол үгсийн язгуурын толь*, Жанг Жияа Кеү, 1988, 2557-2558-р тал.

¹²⁾ Ц.Норжин, *Монгол хэлний үг бүтээх дагаврын хураангуй*, Хөх хот, 2001, 32-33-р тал.

¹³⁾ Тэгшдүүрэн, *Монгол хэлний үг бүтээх ёсны судлал*, Лиюүнинг, 2005-р тал.

¹⁴⁾ Г.Хайрхан, *Монгол хэлний үг бүтэх ёсны судлал*, Хөх хот, 1998, 122-124-р тал.

¹⁵⁾ С.Галсан, *Сопоставительная грамматика русского и монгольского языков (Фонетика и морфология)*, Ч.И. Улаанбаатар, 1975. стр. 155, 160.

¹⁶⁾ Д.Д. Амоголонов, *Современный бурятский язык*, Улан-Удэ, 1958, стр. 158-159.

үеийг давтах (хаб хара, саб сагаан) аргыг хэрэглэдэг¹⁷ гэж үзсэн байна. Тэгвэл Г.Д. Санжеев хожмын бүтээлдээ чанарын зэргийг бууруулах (-втар...) ба эрчимжүүлэх (шав шар) зэрэг буйг¹⁸ дурджээ. Энэ хоёр аргыг Я.Шмидт „ав адил, шив шинэ, сав сайн, (дав дээр), маш их” гэсэн жишээгээр¹⁹ дурджээ.

А.Боброниов "-btur" дагавар нь голлон өнгөнд нэмэлт ялгааны утга илтгэнэ (sira-btur) гээд утгын ялгааны их бага хир хэмжээ зэргийг "-qan, -sig" дагавраар илрүүлдэг (sira-btur-qan, sira-btur-sig), ба утгыг эрчимжүүлэхдээ "ab ariyün, sab šayän"; бууруулахдаа "sine-sig, säyi-sig" гэдэг²⁰ гэсэн байна. Александр Боброниов ulayän-ula-btur, ula-bur- ub ulayän гэх мэтээр тэмдэг нэрийн харьцуулсан (сравнение) ба давуу зэрэг (превосходства)-ийг хоёр ангилжээ.²¹ Ийм ангиллыг А. Попов хийсэн ба юмын өнгийг бууруулахдаа -btur, -qan, bir~ bur залгаврыг хэрэглэдэг²² гэжээ. В.М. Котвич халимаг хэлнээ чанарын зэргийг илтгэх „-qanb” (утгвар бүтээвэр), sig, btur, bur~ bir дагавар буй²³ гэж үзжээ. Н.Н.Поппе багасгах буюу бууруулах утга бүхий "-хан" (улаахан, haixan, yurba-хан), -btur (xarabtar), -bar (nogoobor), -lbar (xөхөlbөр), -ltar (sagältar, ulältör) сDr (xarasar, хунсэг (хүн)), -lgyi (sagältgui, xarDlgui), -xai (subuuxai, dүxei) зэрэг дагаврыг дурдсан байна.²⁴ Б.Х.Тодоева монгол хэлний тэмдэг нэрийн харьцуулсан зэргийг ерийн (урт, хар, их, гашуун, цэвэр), харьцуулсан (газраас илүү өргөн, эхээс дотно, галаас халуун, төмрөөс хатуу ; хөхөвтөр), давуу (маш, нэн, тун, хав хар, муугаас муу, муугийн муу) гэж гурав ялгажээ.²⁵ Г.Д.Санжеев халимаг хэлнээ буурангуй чанарын нэрийг -бтр (шарбтр), буурангуй адилтгасан чанарын нэрийг -шнь (харшнь-черноватый, күүншнь-подобный человеку), өхөөрдсөн буурангуй чанарын нэрийг -кн (холкн, цевркн) гэсэн дагавраар илтгэдэг²⁶ гэжээ. Бүр 1878 онд А.Орлов чанарын тэмдэг нэрийн бууруу шинжийг –хан, хай (хайхан, муухай, шинхэн), -шик, нхи (ехэнхи, набтаршик, бүтүшик (доволно похожий)); -бтур ~ бур ~ бир (хүхэбтэр, хүхэбир) дагавраар илтгэхээс гадна, хүхэбтэрхэн, харабтуршик гэх мэтээр давхарлан хэлэх ба сагахшин (цагаагчин), ламахай, шубуухай хэмээх үгэн дэх дагаврыг жичид нь дурджээ.²⁷ Мөн А. Орлов "metu" гэдгийг "бүтү" гэж хэлдгийг инээхүбүтү айхүбүтү гэж хэлдгийг тэмдэглэсэн нь "metu" хэмээх үгийн me нь bu ~ be-тэй сэлгэдэг болохыг харуулж байна. Энэ санааг батлан В.М. Котвич "-btur" дагавар нь "metu" хэмээхээс эрэлтэй болохыг тэмдэглэж, чанар заасан тэмдэг нэрийн зэргийг -qan, (сайхан), хүбегүн); -b гэсэн өвөрмөц бүтээвэр (частица) (аб аригун); -sig (сайшик), -бтур (цагабтур) -бур (харабир) гэсэн дагавраар

¹⁷⁾ Г.Д. Санжеев, Грамматика бурят-монгольского языка, М-Мр., 1941, стр. 40

¹⁸⁾ Г.Д.Санжеев, Современный монгольский язык, М., 1959, стр. 49.

¹⁹⁾ Д.Шмидт, Грамматика монгольского языка, Спб. 1832. стр. 37-38.

²⁰⁾ А. Бобровников, Грамматика монгольского-калмыцкого языка, Казань, 1849, стр. 65-66.

²¹⁾ Александр Боброниов, Грамматика монгольского языка, Спб. 1835, стр. 37-38.

²²⁾ А.Попов, Грамматика калмыцкого языка, Казань, 1847, стр. 84.

²³⁾ В.М. Котвич, Лекции по грамматике монгольского языка, Пб., 1902, стр. 58-59.

²⁴⁾ Н.Н. Поппе, Грамматика бурят-монгольского языка, М. -Лгр., 1940, стр. 37.

²⁵⁾ Б.Х.Тодоева, Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М., 1951. стр 82-84.

²⁶⁾ Г.Д. Санжеев, Грамматика калмыцкого языка, М., Лгр., 1940, стр. 37.

²⁷⁾ А.Орлов, Грамматика монголо-бурятского разговорного языка, Казань, 1878, стр. 22, 20

илтгэдгийг тодорхойлсон байна.²⁸ Үүнчлэн А.Д. Руднев "-бтур" нь "metü"-ээс үүсэлтэй²⁹ гэж үзсэн байна. Дээрх "metü" хэмээх үгийг халимаг хэлнээ "metü, möt^ö", буриад хэлнээ "betü" гэж хэлдгийг Г.И.Рамстедт тэмдэглээд түрэг хэлнээ "bet" нанай хэлнээ "maty" (адил), самоёд хэлнээ "mitte, mitt" (адил)³⁰ гэж хэлдгийг харьцуулсан бол Т.А. Бертагаев -бтэр дагавар нь "бэтэр-, мэтэр-" хэмээх үгээс үүсэлтэй бөгөөд угтаа "мөн тэр" (mön, tere) хэмээх үгээс мөн тэрэ → мэнтэр → мэтэр → мэт³¹ гэж үүссэн гэж үзжээ. Энэхүү "batu" (нягт бэх холбоотой байх), bitegü (ü) (задгай бус, хаалттай), buta (ургамлын иш, мөчир; бөөн хэсэг, задрах), büte- (аних, эдгэрэх, бөглөрөх, давчдах), bütü- (төрөх, биелэх, үүсэх), bete (нарбил модны үр жимсний гадуурх зузаан арьс → бат бэх арьстай) зэрэг үгсийг харьцуулбал, "бүхэл хэсэг"-ийн буюу уг юмс нягт хэлхээ холбоотой улмаар гадуураа нэлд нь "бүрхэж хаах" гэсэн утгатай байна. Үүнд "ba.. " үе-утгалбар нь бөөгнөрөх, овоорох, эрчих; "-ta..." үе-утгалбар нь өргөсөх, хэсэг хэсэг болох гэсэн утгатай бөгөөд "metü" гэдэг нь нэг юмын доторх хэсгүүдийн нэг нь нөгөөтэйгээ холбогдон улмаар адил төстэй болох гэсэн утгаас үүдэлтэй юм. Эртний түрэг хэлнээ bat- (живэх, шингэх, -нягтрах), bite ~ bitü- (таглах, битүүлэх) botu (ботуул-ургамал), böt (анги, саланги), bötün ~ büten (өөр), buta- (мөчирлөх), butu (ботго), butul- (зүүгдэх), büt- (бүтэх, биелэх, ургах), büte (олон) bütün (бүтэн бүхэл)³² гэж хэлэлцдэг нь ерөнхий болоод зарим утгаараа ижил байгааг Б. Базылханы бүтээлээс үзэж болно. Г.И. Рамстедт, тэмээний нэгээс арван сартай төлийг botuyu ~ botuyā' / çag.botum; bota (хүүхэд, нялх хүүхэд), kir. bota (ботго) гэж харьцуулсан³³ ба энэ нь дээр өгүүлсэн бүхлийн хэсэг буюу ингэнээс гарсан нэг хэсэг, нялх амьтан, эхээс үүдсэн гэсэн утгатай байж болох юм. "metü" гэдгийг халимаг хэлнээ "bütü" гэж хэлдэг тухай А. Орлов тэмдэглэснийг дээр дурдсан билээ. Энэхүү дагавар(угтаа үг)-аас өргөлттэй үеийн эгшиг нь гээгдсэнээр -btur гэсэн дагавар салаалж, уул дагаврын "b" нь бие даасан оруулбар бүтээвэр болохын зэрэгцээ, тухайлбал энэхүү -b-гийн сэлгэмэл "m" хувилбар нь aduyū maduyū qoni moni гэх хоршоо үг бүтээж³⁴, Б. Ринчен гуайн хэлсэнчлэн дуурайх хоршоо үг болжээ.³⁵

Энэхүү "metü" гэсэн нэгж нь нэг талаас sig-тэй утга нэг (çinu-a metü=çinuasiγ) учраас жишихийн тийн ялгалын нөхцөл шиг боловч нөгөө талаар "metüçilen, metürkeü, metü-s" гэж дагавар авах тул үгийн шинжтэй юм. Энэ мэтэд тэр мэт үгийг дуулгаж болохгүй, ном зом, бэх бийр мэтээс авах боллоо. Үнэнчээр зүтгэсэн мэтээр худлаар өгүүлнэ" гэх зэргээр тийн ялгалын нөхцөлөөр хувилна. Энэ нь үгээс бүтээвэр үүсэх явц дахь үзэгдэл бөгөөд монгол хэлний "metu" хэмээгч нь үг бүтээвэр хоёрын завсрын шинжтэй юм. Энэ

²⁸) В.М.Котвич, Лекции по грамматикъ монгольскаго языка, Спб., 1902, стр. 58.

²⁹) А.Д. Руднев, Лекции по грмматикъ монгольскаго письменнаго языка, Спб., 1905, стр. 68.

³⁰) G.Ramstedt, Kalmückisches wörterbuch Helsinki, 1935, p. 262.

³¹) Т.А. Бертагаев, Лексика современных монгольских литературных языков, М., 1974, стр. 249.

³²) Б.Базылхан, Эртний түрэг бичээсний хэлний үгийн бүтэц, Улаанбаатар, 1984, 51-65-р тал.

³³) G. Ramstedt, Дурдсан зохиол, р. 53.

³⁴) М. Базаррагчаа, "м~б" болон "ж" гэсэн авиа-утгалбарын гарал, Улаанбаатар, 2002, 205-207-р тал.

Утгын чуулган; Б" хэмээх оруулбар утгалбар нь утгвар бүтээврийн бүрэлдэхүүнд багтсан нь, МУИС, ЭШБ, XIV боть, 1999.

³⁵) Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр. Өгүүлбэр зүй, Улаанбаатар, 1984, 51-65-р тал

үг-бүтээвэр нь В.М.Солнцевайн үзсэнээр, туслах үгээс туслах бүтээвэр хоёрын завсарт буй хоёрдмол шинжтэй нэгж болно.³⁶ Энэ "metü" нь хуурмагаар нэрийн нөхцөлөөр хувилавч бусад үгстэй адилаар бие даасан шинжгүй юм. "Адил төстэй" гэсэн утга бүхий "metü" хэмээх үг нь нэр үйлийн өмнө үл хувилах үгсийн аймгийн үгстэй адилаар тодотгох утгатай тэг үндсээр хамжиж ордог. Жишээ нь Арслан мэт ноёдыг барс мэт түшмэл дагах, Барс мэт ноёдыг ирвэс мэт түшмэд дагах, Чоно мэт ноёдыг үнэг мэт түшмэд дагах тул хамагт зовлон болмуй (Оюун түлхүүр). Ёнхор энэ мэт олныг бодно. (С.Э). Асрын гадуур харуулын тангад мягуу мэт зөөлнөөр гишгэлэн шуухитнаж, морьд ногоо шир шир хазлан, тооройн навч үүрийн зөөлөн салхинаа сэрчигнэх сонсогдоно.(С.Э) Гангийн гал наранд ангаж ядарсан хүмүүс ёстой л авралын орны бараа харсан мэт ямар их баярлаж байлаа (С.Э).

Энэ үг-бүтээвэр нь жинхэнэ нэр болон түүнийг орлосон үгсийг нэр үйл үгнээ голдуу адилтгах утгаар холбох боловч тийн ялгалаар хуурмаг хувилахдаа "зэрэг хам" гэсэн утгыг илтгэдэг ажээ. Үүнд,

Нэрлэхийн т.я: Даваа мэт нь ирсэнгүй

Заахын т.я: Дэндвэл, мань мэт-ийг ч тэр мүзүүдээ тавих нь холгүй (С.Э)

Харьяалахын т.я: Энэ тэр мэт-(ийн) явдлаас ер хоцордоггүй хүн шүү, би.

Хамтрахын т.я: Согтуу Палхаа мэттэй нөхөрлөвөл сайнаа үзэх үү?

Үйлдэхийн т.я: Энэ мэтээр элдвийг хөврүүлэн бодно.

Өгөх-оршихын т.я : Уул усны савдаг лус мэт-д өглөг өргөл барьдаг боллоо.

Гарахын т.я: нааш цааш, өөд уруу явах мэт-ээс хашраад байжээ.

Чиглэхийн т.я: Самдан Мамдан мэт рүү явуулаад байх хэрэггүй шүү.

Тэгшхэн зассан дэлтэй, хад мэт хантраастай, сайхан халтар морь, зүүн гартаа цулбуураа бариад, урт гансаа яаралгүй татаж суусан эзнээ байн байн харж, соргог хоёр чихээ солбилзуулан зогсож байв. (Б.Ринчен Үүрийн туяа)

Миний хорхой мэт амийг уучлан хайрлаа!... (Б.Ринчен Үүрийн туяа)

Харин бид мэтийн ядсан амьтанд олдошгүй юм шүү дээ. (Б.Ринчен Үүрийн туяа)

Тэр адгийн урт эгшиг нь өнгөрсөн цагийг үзүүлэгч ай, эй дагаврын дээр -й гэж сэтгэлд үргэлжлэн буйн байдал бүхий утгыг үзүүлсэн түүн лүгээ нийлж Урт эгшиг мэт дууддаг болсон нь эгч ээ! ах аа! гэж дуудахын тийн ялгалын аа, оо, ээ, өө гэдэгтэй адилгүй тул, эгч ээ, ирлээ, ах аа би соносовоо гэх мэтэд хоёр өөр зүйл буй. Нэг нь дуудахын тийн ялгал, тэр нь гагцхүү нэрийн зүйлд байдаг. (Б.Ринчен Үүрийн туяа)

---- Хадаг барьж, залан айлтгахыг хүлээж байгаа хэрэг үү? гэж Жантайн дуугарахад, Ширчингийн дотор их л урамгүй болж, аман дотроо Ширчинг үглэж яваа Думаа эмгэнийг дагасаар гэрт орвол, тулганд асаж байсан аргалын сүүмэлзэх гэрэлд Думаа Ширчингийн дэргэд амтгүй хатуу махтай туранхай хонины хүзүү идээд үлдээсэн махны хальс мэтийг ойртуулж тавьсан нь баян айлд зарцлагддаг ядуусын өл залгадаг хоол байжээ. (Б.Ринчен Үүрийн туяа)

Үг зохиох найруулахдаа чадамгай залхай зуйгар Оссендовскийг хэрэглэж, Барон өөрийн биеийг <<Монгол улсад маш ачтай бөгөөд түмэн үеийн түүхэнд их гавьяа

³⁶⁾ В.М. Солнцев, Язык как системно-структурное образование. М., 1971. стр 259.

үлдээсэн Дайчин улсыг дахин мандуулж, дэлхий дахиныг хувьсгалч нарын хорлон хөнөөхөөс аврах их үйлсийг бүтээх заяатай билээ>> гэж солиотой галзуу мэтээр тунхаг бичүүлэн тараажээ. (Б.Ринчен Үүрийн туяа)

Дэлхийн олон өнгийн оросын дотроос хамгийн хүчирхэг болоод ариун шударга нь улаан орос улс гэнээ ч гэх шиг, ард түмний дотроос Сүх хэмээх бууны суманд үл даагдах баатар эр тодрон энх цагийг тогтоох гэлээ ч гэх шиг, түүний цэрэгт элсэн орж амь бие хайргүй зүтгэвэл энэ насны эрхэм дээд жаргал, эцэс хойддоо эгэл бусын төрөл олно гэх мэтчилэн өнгө будаг нэмэгдэн дэгдэж, олны сэтгэлийг сэргээжээ. (Д.Намдаг Цаг төрийн үймээн)

Харин жишихийн тийн ялгалын "шиг" нөхцөлийн оронд энэ "мэт" хэмээхийг хэрэглэж болно. Жишээ нь: Бүх юм зүүд шиг (С.Э)-Бүх юм зүүд мэт.

Бурхны оронд очиж тэнгэрийн дагина шиг амьдар! ~ Бурхны оронд очиж, тэнгэрийн дагина мэт амьдар!

Гэвч тааварлах утга бүхий "шиг" нөхцөлийн оронд "мэт" хэмээгч үг-бүтээврийг хэрэглэж болдоггүй. Жишээлбэл, Тэр байн байн хараад байвал тэсэхгүй гэсэн шиг өнөөдрийг хүртэл хэдхэн удаа л орж иржээ (С.Э). Нарангарвуу зүүдэнд байгаа юм шиг удаан хөдлөлгүй хэвтлээ (С.Э) Үүнчлэн "мэт" бүхнийг "шиг"-ээр солиход найруулгын өнгө аяс эвдэрч байна. Жишээлбэл, Хөх ногоон, ухаа шаргал алагласан энэ их тал нутаг ертөнцийн түмэн галавт ийнхүү амгалан бөгөөд хувиршгүй мэт боловч, хүний үр нэгэн төрөл өнгөрөх хооронд юуг эс үзнэм билээ (С.Э). Ёнхор өвгөн энэ мэт өнгөрснийг эргэцүүлэн тал нутгаа ширтэн явав (С.Э). Гэтэл "мэт"-ийг "шиг"-ээр сольж болох нь бас бий. Тухайлбал, Залуугийн цаг одоо үлгэр түүх мэт (шиг) боловч ямар гайхамшигтай байх вэ! (С.Э). Хүн хүсвэл түүнийг нь ойлгож болохоор тийнхүү ойлгохоор тийн ойлгох нь хүний өөрийн ухаан, нүд чихний хурц сонороос л болох зүйл мэт (шиг) санагдана (С.Э).

"Мэт" нь адилтгах утгаар сонгодог бичгийн хэлнээ "шиг" нь жиших, тааварлах утгаар өнөөгийн бичгийн ба ярианы хэлнээ тус тус түгээмэл хэрэглэж байна. Д. Батбаяр "мэт" хэмээх үг-бүтээврийг эргэцүүлэн адилтгах өгүүлэмж бүтээхдээ олшруулан овоолох аргад ашиглажээ. Үүнд:

Дув дугуй мэт дув дуугүй, хязгаар хярхаггүй, харанхуй мэт, мэдэхгүй мэт, чанад мэт, бус мэт өнгөгүй, үнэргүй, аниргүй, дув дуугүй нь уртгүй, өргөнгүй, өндөргүй. Үгүй мэт, нууц мэт, эгшиг мэт дув дуугүй нь цэг мэт (Амрагийн тэнгэр 68-р т.) Үүн доторх "дув дугуй, дув дуугүй" гэхэд орсон "b" нь дээр өгүүлсэнчлэн metü (мэт) гэдгийн "m" нь "b"-тэй сэлгэж оруулбар бүтээвэр болсон нь юм.

Ш.Лувсанвандан гуай Энэ "шиг" гэдэг нөхцөл нь дан ганц нэр үйлийн хоорондын харьцааг заах төдийгүй, хоёр нэрийн хоорондын харьцааг зааж чадаж байна. Жишээлбэл, хөгшин аав шиг-ээ өвгөн хүнийг хүндлэх хэрэгтэй. Дүү шиг-ээ бага хүүхдийг асрах хэрэгтэй³⁷ гэж өгүүлж, энэ нөхцөлийг хааяа орлох "мэт" гэсэн адилтгах нэгж (үг-бүтээврээс) ялгаатай гэж үзсэн нь илт байна. Цаашилбал "bvtv" гэсэн бүтцээс

³⁷⁾ Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц, монгол хэлний үг нөхцөл хоёр нь, Улаанбаатар, 1968. 55-р тал.

оруулбар ба угтвар бүтээвэр үүсэхийн зэрэгцээ "-btur" → "-bċi" дагавар салаалсан байна.

Үүнд:

-bċi

↑

-btur~tur (sāyi-tur)

↑ batu (бат бэх)jen-ostj.but(id)

ubulagān-b ← bütü ← bütü- (ажил бүтэх, төрөх, боловсрох) tū.bit- uig. püt-büt- (bütü-)

(оруулбар бүтээвэр) büte-g ē (хучих, халхлах, бөглөрөх, аних, эдгэх)

büte-gū(ü) (далд, задгай бус, балар), kir. bitä (хаах)³⁸, bim bitegū

adaγū→maduγū

-m ← mutu ← buta (бут мөчир, бөөн хэсэг, бяц), kir.butа (бут), зак. butа (бут.)

mötü ← botiγül (үет өвс), botuγu (тэмээний төл, ботгон хүлэг (эцэж цуцахгүй номхон (угтвар морь)

бүтээвэр betü ~ metü ← (наржил мод, зузаан арьстай, түүгээр нь хувин аяга, уур хийнэ.)³⁸ гэж харьцуулбал, "ba... " үе-утгалбар нь эрчлэн бөөгнөрөх, нягтрах, "tu... " нь „тусгах, нийлэх” гэсэн утгатай учраас бат бэх холбогдох, гадуураа бүтээгдэх, болж бүтэх, үндсээсээ бутлах (бүхэл хэсэг) гэсэн утгат дээрх үг салаалсны дээр хоёр юм адил болох” гэсэн утга үүсжээ. Энэ тухай Г.И. Рамстедт халимаг хэлнээ metə, bütü (bütü, metü)³⁹ гэсэн хэлбэртэй байдгийг тэмдэглэсэн бол С.Старостин, А. Дыбо, О. Мудрак нар „metü хэмээх үгийн эртний хэлбэрийг "miati" гэж сэргээгээд, эртний түнгүс хэлнээ "miati" (амьтны толгойн арьс), эртний түрэг хэлнээ "bet" (нүүр, тал, ойр), өнөөгийн япон хэлнээ nutai (адил, төстэй)⁴⁰ гэж харьцуулжээ. Халимаг, ордос хэлнээ энэ үг-бүтээврийг "mötə", дуншаан хэлнээ, "mutu", Баоань хэлнээ "mätgo", монгол хэлнээ "madu" гэж хэлдгийг дурджээ. С. Старостин нар "metü" хэмээх үгийн эртний хэлбэрийг "miati" гэж сэргээснээс үзвэл "i" эгшгийн өмнөх "t" нь зөөлөн "č" болон хувирах тул түүнээс тухайн юмын гадуур бүрхэж, уг юмыг багтаах гэсэн утгатай "bċi" дагавар монгол хэлнээ үүсжээ. Уг юмыг бүрхэх халхлах гэдэг нь цаад юмын овор төрхийн дагуу хэвтэй буюу адил төстэй байх нь мэдээж юм. Жишээ нь, хурууг хамгаалах зүйл нь хуруутай төстэй байж "хуруу-вч" гэх үг бүтэх биз ээ.⁴¹ quruγū-bċi, qoγūlāyi-bċi, elige-bċi, nari-bċi, бүдүгү-bċi.

А.Бобровников "-btur" дагавар нь зонхилох өнгө дагуу хөнгөвтөр өнгө оруулсан утгатай бөгөөд орос хэлний "-оватый" хэмээх дагавартай төстэй юм. (sira-btur, kŭke-btur) гэсэн бол "-bċi" дагавар нь нэг юмыг далдлах халхавч хаалт болдог гэсэн утгатай (ebċigū-bċi, dala-bċi)⁴² гэж үзжээ. Г.И.Рамстедт монгол хэлний "bċi-н" дагавар нь түнгүс

³⁸) G. Ramstedt. Дурдсан зохиол, р. 46

³⁹) G. Ramstedt. Дурдсан зохиол, р. 43

⁴⁰) S.Starostin, А.Диво, О.Мадрак, Etymological dictionary of Altaic languages, Leiden, Vocton 2003, р. 924.

⁴¹) М. Базаррагчаа, Монгол хэлний нөхөцмөл „в-чи” дагаврын гарал, Монгол хэл шинжлэл, 5(27) боть, Улаанбаатар, 1999, 71-88-р тал.

⁴²) А.Бобровников, Грамматика монгольско-калмыцкаго языка. Казань, 1849, стр. 66.

хэлний "-ptun"(-pun, btu, tun)-тэй тохирно гээд čike-bči, quruγū-bči, sūke-bči, γara-bči, kǔjēgū-bči, qoγōla-bči зэрэг жишээ татан, манж хэлний хуситун (хөлийн ороолт) гэсэн үйл үгийн хуси язгуурыг монгол хэлний quči-(хучих ороох) гэсэн үгтэй холбожээ.⁴³ Н.Н.Поппе -bči дагавар нь "юмын халхавч, гэр дугтуй" гэсэн утгатай (kete-bči, qoγūla-bči, kǔjūgū-bči), -btur дагавар нь "өнгөний буруу" шинжийг заасан утгатай (qara-btur, čaγā-bir, ulaγā-bur, sira-bur, kōke-btur)⁴⁴. Тэрээр -bči нь ямар нэг зүйлийг "бүрхэх таглах, хучих" (čike-bči, dala-bči, nidū-bči, elige-bči), -bir, -btur нь "өнгөний ялгүй бүдэг" (čaγā-bir, ulaγā-bir, kōke-btur, ulaγā-bur, ноγуγā-bur, ulaγā-bur), -čar (qara-čar) гэсэн утгатай⁴⁵ хэмээн үзжээ.

У-Ж.Ш.Дондуков гуай "-бша" (bči) дагавар нь а) үйлийн хэрэглүүр болсон юм. (холхибшо (инструмент для чистки ушей от серы); б) язгуурын утгад тохирсон юмын нэр (хандайбша-небольшая табуретка), дүрөөбшэ (кожа между седлом и стремени); в) юмын халхавч, сав болж буй юм (кэтэбшэ, халхабша); г) аль нэг эрхтний нэр (далабша, эрхыбшэ); д) аль нэг эрхтнийг хамгаалах, зүүх, өмсгөх юм (хоншообшо (намордник), хүзүүбшэ, үбсүүбшэ (нагрудник) гэж ангилаад, нуурибша (небольшой потник) гэхэд „-вша” дагавар нь "багасгах" утгатай гэж үзсэн байна⁴⁶. Т.А.Бертагаев "-bči" дагавар нь бодтой ба хийсвэр утгат үг бүтээнэ гэж үзээд, "хуруувч, гэгээвч, хэтэвч, нуруувч" гэвэл бодот юмс, "сэхээвч, (разум, ум, соображение), оно-вч (конкретность), гэрэвч (канделябр, люстра), даравч (шпоры), бүдүү-вч (схема)" зэрэг хийсвэр зүйлийн утгатай гэж ангилжээ⁴⁷. Мөн Г.Ц.Пюрбеев "-bči (вч)" дагавар нь нэр томъёоны хувьд идэвхтэй хэрэглэгддэг дагавар болно гэж үзээд, аж ахуйн холбогдол бүхий овор багатай зүйлс, хэрэглэл, зохион бүтээсэн юмсын нэрлэсэн нэр томъёо олонтоо тохиолддог, тухайлбал, гогцоо-вч, холхи-вч, чих-вч, талхи-вч, оно-вч, эрхий-вч, дар-вч (шпора, шайба), нүд-вч, нуруу-вч, хүзүү-вч, хоншоо-вч, хуруу-вч, зүүвч (игольница), урх-вч (силки, петли), амгай-вч, хэт-вч, халх-вч, салхи-вч, гэгээ-вч, дал-вч, үүрэг-вч, үүд-вч (том хотирхой гэдэсний үүдэвч), өндөг-вч (яичко), тасал-вч (хамрын таславч-носовая перегородка) гэх мэт жишээг татжээ⁴⁸.

Цаашилбал, Д.А.Сусеева халимаг хэлнээ "улавър, цаһавър, хоосъвър, зузавър, хоосър, жөөлэр, нимгэр, икевцер, муувтър, сээвер (сайн), көгшэвер, һалзвьцър" гэх мэт дагавраар илрэх тэмдэг нэр нь өнгөний буруу шинжийг илтгэдэг⁴⁹ гэж үзсэний доторх хоосър (хоосоор), жөөлэр (зөөлнөөр), нимгэр (нимгэнээр), сээвер (сайнаар) зэрэг үгс нь үйлдэхийн тийн ялгалт тэмдэг юм. Үүнийг Д.А.Сусеева "Дайвар үг" гэж үзсэн байна. Халимаг хэлний "-бцер" дагавар нь "-бтър" дагаврын хувилбар болох ба юу гэвэл, "-btur (втър)" хэмээх дагаврын "tu" нь "ča-či"-тэй сэлгэснээс үүссэн ажээ. Жич, энэхүү "-btur"

⁴³) Г.И.Рамстедт, Вседение в алтайское языкознание, М., 1957, стр. 205.

⁴⁴) Н.Н.Поппе, Грамматика письменно-монгольского языка, М.-Лгр., 1937, стр. 106-108.

⁴⁵) Н.Поппе, Монгол бичгийн хэлний зүй. Улаанбаатар, 2012, 58-59-р тал.

⁴⁶) У-Ж.Ш.Дондуков, Аффиксальное словообразование частей речи в бурятском языке, Улан-Үдэ, 1964, стр.11; Словообразование монгольских языков. Улан-Үдэ, 1993, стр. 31

⁴⁷) Т.А.Бертагаев, Лексика современных монгольских литературных языков. М., 1974, стр. 205-206.

⁴⁸) Г.Ц.Пюрбеев, Современная монгольская терминология. М., 1984, стр. 55-56.

⁴⁹) Д.А.Сусеева, Слообразовательная парадигматика имен прилагательных в современном калмыцком языке. Алтайские языки и восточная филология, М., 2005, стр. 404-412.

дагаврыг "sayi-btur (саявтар), ayiqu-btur (айхавтар)" гэж залгадаг нь зүй тогтлыг зөрчиж бүтсэн тайлагдал болох ба энэ нь уг дагавар маань баймж утгыг илтгэдэг учраас цагийн нэр ба ирээдүй цагт нэрнээ залгасан байдаг.

"-bči" дагаврын талаар Ш.Цэцэнцогт дундад зууны монгол хэлнээ цөөвтөр хэрэглэдэг байснаа одоо идэвхтэй хэрэглэдэг дагавар болсон бөгөөд монгол хэлнээ "bdʒэ, rdʒi", зүүн ёгор хэлнээ "btsə", дагуур хэлнээ "-rts", бао ань хэлнээ "rdʒ", манж-түнгүс хэлнээ "-ptun, tun, ptu, run, ttan, ttun" гэж хэлдгийг харьцуулжээ⁵⁰. Тэрээр, энэ дагаврын хэлбэр ба утгын талаар нь 1. NN: Тухайн юмыг бүрхэх, халхлах, савлах буюу түүнд углах зэрэг эд хогшлийг заасан нэр үг үүсгэнэ. Жишээ нь, elige-, on-(oni)-, dōrū-, erkei-, quruū, qoūlāi-, toyī-(u)-, mangnāi-, čiki-, qača(r)-, qormui-, omuruñ-, tasiyā-, kǔjūgū-, suyu-, ala-, gegē-, salki-, toyūsu-, jula-, sara-, nari(n)-, geǰige-, ōndege-, dalu-, ōngge-, niyūr-, qayaū-, gere-, kegere-(хээр хэрэглэх сав), qalqa-, jēgū-bči-, čegeǰi-, sirquna(γ)-, γoūcyūā-bči; (ebūdūg-(b)či, čegeǰimeg-(b)či, qormui-g-b-či).

2. V→N: Тухайн үйлийг гүйцэтгэгч багаж хэрэгсэл ба тухайн үйлийн явц зэргийн хэр хэмжээ заасан нэр үг үүсгэнэ. elgū-, niyū-, egūr-, qolki-, tata-, būrkū-, negegē-, onu-, daru-bči;

3. N_{adj}→N: Тухайн шинж тэмдэг бүхий хэрэг явдал, юмыг заасан нэр үг бүтэнэ. nari(n)-bči, būdūgū(n)-bči, dalda-bči, bariyū-bči, jōgēle(n)-bči, tasiyū-bči, qur-du(n)-bči, neyi-bči, sira-bči(шар бидэртэй хэрээ)

4. N_{adj}→N_{adj}: Тухайн шинж тэмдгийн барагцаалсан байдал төлөвийг илтгэх тэмдэг үг үүсгэнэ. narī-bči(нарийн төлөв), būdūgū-bči(бүдүүвч зураг, үлгэрийн бүдүүвч), yeke-bči, kōngge-bči.

5. N→N_{adj}: Тухайн зүйлсийн шинж байдал бүхий тэмдэг нэр үүсгэнэ. ōngge-bči

6. O→N: qarīyū-bči (qaritu, qarīči), belke-bči (belkenčeg), qolqu-bči;⁵¹

Ийнхүү "-btur" дагавраас "-bči" дагавар, "bčur" (ula-bčur-ул, хэт цахиур агуулах хэрэгсэл улавч) үүссэн бол "b" нь гээгдэж "сэлгэмэл г-γ гэсэн дагавар бүхий √ -цаг, či-г хэмээх дагавар салаалжээ. Жишээ нь, noqāyi-čir, činu-čir, solungγa-čir, kōbūng-čir, udum-čir, ebečin-čir, manan-čir, bal-čir, quluγana-čir, ōl-čir (kōlčir), āyil-čir, ebūgen-čir, qoūlan-čir, boγu-čir, teneg-čeg, busu-čir, jūibang-čir гэхэд "čir, čur" дагавар нь, уг юмын бүүрүү шинж, тарамдсан шинж, багассан (бүдэг) шинж зэрэг утга илтгэж байна. Энэ нь угтаа "-btur" буюу "metū" гэсэн утгат дагавраас үүсэлтэй болох нь тодорхой байна. Иймээс У-Ж.Ш.Дондуков гуайн тодорхойлсон, буриад хэлний "зээ-нсэр, бүлэ-нсэр, хүн-сэр (человечишко) мори-сор (лошаденка), гэр-сэр (юртишка)" гэсэн дагавар нь "зээ"-тэй "адил" охиныг "зээ-нцэр" гэжээ.⁵² Энэ kǔmūn-čeg (хүнсэр, хүнэнцэр) хэмээх үгнээ орсон "хүн мэт, хүний оронцог" гэсэн утгатай "čeg" дагаврын "г" нь "γ"-тэй сэлгэж, oγun-čay, qanggir-čay, kengger-čey, bōmbūr-čey, ala-čuy (хатгуур гэр), qayūr-čay, tōgū-čeg, ayār-čay, egēr-čeg, aγul-čay, tobur-čay, oγūr-čay, janggir-čay, palang-čay, olung-čuy, yanggir-čay (хэдэн модыг хэлхэн зангидаж хийсэн эмээлэрхүү эдлэл), kingγar-čay, oγūr-čuy, oγum-čuy

⁵⁰ Ш.Цэцэнцогт, Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кеу, 1988, 2556-р тал.

⁵¹ Ш.Цэцэнцогт, Дурдсан зохиол, 2556-2558-р тал.

⁵² У-Ж.Ш.Дондуков, Дурдсан зохиол, стр. 24-25.

